



ХҮН АМЫН ХӨГЖИЛ, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН САЙДЫН ТӨСВИЙН БАГЦЫН 2014 ОНЫ САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН

АГУУЛГА

**Нэмэлт мэдээлэл авахыг хүсвэл
дараах хаягаар харилцана уу:**

YAG-ын Санхүүгийн аудитын газрын
дарга,
Тэргүүлэх аудитор С.Энхзаяа
Утас: 261663
Цахим хаяг:
enkhzayas@audit.gov.mn

Аудитын менежер: С.Оюунгэрэл
Утас: 260512
Цахим хаяг:
oyungerels@audit.gov.mn

Ахлах аудитор: Д.Цэрэндорж
Утас: 261740
Цахим хаяг:
tserendorjd@audit.gov.mn

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

Засгийн газрын IV байр
Бага тойруу 3
Улаанбаатар-15160
Монгол Улс

Цахим хаяг: www.audit.mn

2015 оны 4 дүгээр сар

Аудит хийх хууль эрх зүйн үндэслэл
Байгууллагын хууль, эрх зүйн орчин
Байгууллагын зорилго, үйл ажиллагаа
Аудитын шалгуур үзүүлэлт, аудитын арга зүй,
хэрэгжүүлсэн горим, хяналтын сорил болон
нарийвчилсан горим, түүний үр дүн
Дотоод хяналт
Төсвийн орлого, зардлын гүйцэтгэл, түүний талаарх
тайлбар
Шилэн дансны мэдээлэл
Олж тогтоосон гол эрсдэлүүд, түүний үр дагавар
Гол, онцлог гүйлгээний талаарх (тохиромжтой бол)
тайлбар
Аудитаар илрүүлсэн гол зөрчлүүд, тэдгээрийг
шийдвэрлэсэн талаар
Материаллаг бус залруулагдаагүй алдаануудын
талаарх тайлбар:
Анхаарал татахуйц бусад чухал асуудал
Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд
Санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн
зөрчлийн нэгтгэл
Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт
Зөвлөмж
Аудитын гэрчилгээний тохирох загварын талаарх
дүгнэлт
Аудитын гэрчилгээ
Менежментийн захидал
Аудит хийгдсэн санхүүгийн байдлын нэгтгэсэн
Тайлан
Аудит хийгдсэн санхүүгийн үр дүнгийн нэгтгэсэн
тайлан
Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний нэгтгэсэн тайлан
Аудит хийгдсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн
нэгтгэсэн тайлан
Төсвийн гүйцэтгэлийн нэгтгэсэн тайлан

Аудит хийх хууль эрх зүйн үндэслэл

Төсвийн тухай хуулийн 8.9.5, Төрийн аудитын тухай хуулийн 15.1.1 дэх заалтыг үндэслэн Төрийн аудитын тухай хуулийн 18.2 дугаар зүйлд заасан Үндэсний аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын сайдын төсвийн багцын 2014 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайланд /ҮАГ-2015/11-СТА-ТЕЗ / аудит хийлээ.

Аудитыг Төсвийн тухай, Төрийн аудитын тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулиуд болон холбогдох бусад хууль, тогтоомжийн хүрээнд Аудитын олон улсын стандартын зарчмуудад нийцүүлэн төлөвлөлтийн шатанд боловсруулсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын сайдын төсвийн багцын 2014 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт /УСНББОУС/, түүнд нийцүүлэн гаргасан улсын төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн ерөнхийлөн захирагч санхүүгийн тайлангаа УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан холбогдох журмууд, төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, програм хангамжийн дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Тухайн санхүүгийн нэгтгэсэн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС-тай нийцүүлж материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын сайдын төсвийн багцын 2014 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитыг 2015 оны 4 дүгээр сарын 05-наас 2015 оны 4 дүгээр сарын 25-ны хооронд хийхээр төлөвлөн Үндэсний аудитын газрын САГ-ын Ахлах аудитор Д.Цэрэндорж хэрэгжүүлэв. /ТАБ-СТА-А-9/

Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын сайдын төсвийн багцын 2014 оны санхүүгийн нэгтгэсэн тайланг 2015 оны 4 дүгээр сарын 6-нд Үндэсний аудитын газарт ирүүлсэн байна.

Үндэсний аудитын газар аудитыг 2015 оны 4 дүгээр сарын 16-наас 2015 оны 4 дүгээр сарын 25-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2015 оны 4 дүгээр сарын 27-нд Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын сайдад гардуулна.

Байгууллагын хууль, эрх зүйн орчин

Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын сайд, түүний эрхлэх асуудлын хүрээний байгууллагууд нь Нийгмийн даатгалын тухай, Нийгмийн халамжийн тухай, Хүний хөгжлийн тухай, Төсвийн тухай, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай, Төрийн болон орон нутгийн өмч хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулиудын хүрээнд үйл ажиллагаа явуулж байна. Тайлант онд тухайн байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг гол хууль, тогтоомж, түүнд нийцүүлэн гарсан журам, зааварт өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын зорилго, үйл ажиллагаа

1. Монгол хүний амьдралын чанарыг дээшлүүлж, хүн амын хөгжлийг хангах нийгмийн таатай орчныг бүрдүүлэхэд чиглэсэн нийгмийн цогц бодлого боловсруулж хэрэгжүүлэх;
2. Нийгэм, эдийн засгийн өөрчлөлт, хүн амын насны бүтцийн хэтийн төлөвийг харгалзан хүн амын бүлгүүдийн хэрэгцээнд нийцсэн нийгмийн даатгал, нийгмийн халамжийн үйлчилгээний чанар, үр ашгийг дээшлүүлэх замаар хүн амын нийгмийн хамгааллыг сайжруулах;
3. Удирдлагын үр ашигтай арга барил, туршлага нэвтрүүлэх, төлөвлөх, тайлагнах, хариуцлага тооцох тогтолцоог хөгжүүлэх замаар төрийн захиргааны удирдлагын манлайллыг хангах, хүний нөөцийн чадавхийг бэхжүүлэх; гэж энэ байгууллагын үйл ажиллагааны зорилтыг тодорхойлсон байна.

Дээрх зорилтыг хэрэгжүүлэхийн тулд Монгол Улсын Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1.8-д “Засгийн газрын гишүүн холбогдох төрийн захиргааны төв байгууллагын болон түүнд хууль тогтоомжоор харьяалуулсан бусад байгууллагын төсвийн ерөнхийлөн захирагч байна” гэж заасны дагуу Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын сайд төсвийн ерөнхийлөн захирагчийн үүргийг гүйцэтгэж байна.

Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.4.4-т “төрийн захиргааны төв байгууллагын Төрийн нарийн бичгийн дарга тус байгууллагын төсвийн шууд захирагч байна” гэж заасны дагуу Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын яамны аппаратын төсвийн шууд захирагчийн үүргийг яамны Төрийн нарийн бичгийн дарга гүйцэтгэж байна Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын сайдын төсвийн багцын 2014 оны төсвийг Сангийн яамны төрийн сангаас олгож байна.

Төсвийн ерөнхийлөн захирагчтай холбоотой эрх зүйн баримт бичгийг судалсан бөгөөд Төсвийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай, Төрийн болон орон нутгийн өмч хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай болон холбогдох бусад хуулиудыг хэрэгжүүлэн ажиллаж байна.

Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын сайдын төсвийн багцын үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд ТАБ-СТА-А-1 маягтад тодорхой тусгасан.

Аудитын шалгуур үзүүлэлт, аудитын арга зүй, хэрэгжүүлсэн горим, хяналтын сорил болон нарийвчилсан горим, түүний үр дүн

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг шалгуур болгон ашиглав.

Аудитаар Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын сайдын төсвийн багцын 2014 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд дүгнэлт өгөх үүднээс төсвийн ерөнхийлөн захирагчийн удирдлагын бэлтгэсэн санхүүгийн тайлан нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд төсвийн дансдын уламжлалт эрсдэл болон хяналтын эрсдэлийг тогтоон тухайн байгууллагын зүгээс тавьж буй дотоод хяналтыг үнэлж баримтжууллаа. /ТАБ-СТА-А-5/

Санхүүгийн тайланг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, зарим гүйлгээ ихтэй томоохон дансдад түүвэрчилсэн байдлаар аудитын нарийвчилсан горим, сорил 17-г гүйцэтгэв. /ТАБ-СТА-В-3/

Тухайн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, системтэй танилцахад Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын сайдын төсвийн багцын санхүүгийн үйл ажиллагаанд хэрэглэгдэх нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг боловсруулан 2011 оны 5 дугаар сарын 4-нөөс эхлэн мөрдөн ажиллаж байгаа ба УСНББОУС, хууль эрх зүйн өөрчлөлтийг тусган шинэчлэн батлуулахаар бэлтгэсэн байна.

Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын сайдын төсвийн багцын санхүүгийн үйл ажиллагаанд ашиглагдаж байгаа компьютерийн системийн үйл ажиллагаатай асуулга явуулах аргаар танилцан түүний нарийн төвөгтэй байдлын үнэлгээг хийхэд бага буюу мэдээллийн технологийн мэргэжилтэнг оролцуулах шаардлагагүй гэсэн үнэлгээ авсан тул аудитыг шууд гүйцэтгэлээ. /ТАБ-СТА-В-2/

Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын сайдын төсвийн багцын санхүүгийн үйл ажиллагааг бүртгэх, хянах, боловсруулах үйл ажиллагааг санхүүгийн програмаар боловсруулан санхүүгийн тайлан бэлтгэх аргачлалын дагуу санхүүгийн тайланг гаргасан байна.

Дотоод хяналт

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс дотоод хяналтыг төлөвлөсөн горимын дагуу сорьсон. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалахын тулд жилийн турш үр нөлөөтэй ажиллах ёстой гол хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын сайдын төсвийн багцын дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үед бага гэж тооцсон ба дахин хянахад дотоод хяналтын тогтолцоог боловсронгуй болгох, өмнөх аудитаар илэрсэн төлбөр, зөрчлийн барагдуулалт, өгсөн зөвлөмжийн хэрэгжилт хангалтгүй, Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын сайдын төсвийн багцын харьяа зарим байгууллагын үйл ажиллагаатай холбоотой хууль хяналтын байгууллагад шийдвэрлүүлэхээр өгсөн асуудлын шийдвэрлэлт удаашралтай байна.

Төсвийн орлого, зардлын гүйцэтгэл, түүний талаарх тайлбар

2014 оны батлагдсан төсвийг сар, улирлын хуваарийн дагуу Төрийн сангийн харилцах дансаар дамжуулан санхүүжүүлснээс гадна төсвийн хүрээний мэдэгдлийг боловсруулах, төсвийн санхүүжилтийн гүйцэтгэлийг хангах, төсвийг зардлын төрөл зүйлээр хуваарилах зэргээр гүйцэтгэлд хяналт тавин ажилласан байна.

Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын сайдын төсвийн багцад 2014 онд улсын төсвөөс урсгал зардалд 339,509.1 сая, хөрөнгийн зардалд 22,487.4 сая, нэмэлт санхүүжилт 2,999.1 сая, нийгмийн даатгалын сангаас 539.0 сая, тусгай зориулалтын шилжүүлгийн санхүүжилт 6,088.0 сая, төсөвт байгууллагын ажил, үйлчилгээний орлогоос 3,427.1 сая, хөрөнгийн орлого 14,418.2 сая, нийт 389,467.9 сая төгрөгийн орлоготой ажилласан байна. Үүнээс урсгал зардалд 445,960.4 сая төгрөг батлагдсанаас 369.841.1 сая төгрөгийг зарцуулж, батлагдсан төсвийг 76,119.3 сая төгрөгөөр хэмнэсэн байна.

Төв төрийн сангаас батлагдсан төсвийн хуваарьт сар бүрийн зарцуулалтын эрхийн баталгааг үндэслэн харилцах дансанд бодит гүйцэтгэлээр 190.0 сая төгрөгийн санхүүжилтийг бүрэн нээж, Үндсэн үйл ажиллагааны орлогоос 2,557.2 сая төгрөг, туслах үйл ажиллагааны орлогоос 4,451.9 сая төгрөгийн гүйцэтгэл гарч үлдэгдэл 7,009.1 сая төгрөгийг төвлөрүүлсэн байна.

Төсвийн төлөвлөлтийн талаар: Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын сайдын төсвийн багцын тодотгосон төсвийг УИХ –аас 2014 оны 12 дугаар сарын 19-нд 445,960.4 сая төгрөгөөр батласан байна.

Төсөвт зардлын талаар: 2014 оны төсөвт зардал 445,960.4 сая төгрөгөөр батлагдсанаас 369,670.9 сая төгрөг зарцуулж, нийт батлагдсан төсвийн 82.9 хувийг санхүүжилтээр олгож, төсөвт зардал 76,289.6 сая төгрөгөөр хэмнэгдсэн үзүүлэлттэй байна.

Хөрөнгө оруулалтын талаар: 2014 онд хөрөнгө оруулалтын зардалд 28,247.6 сая төгрөг батлагдсанаас 22,487.4 сая төгрөгийн санхүүжилт хийгдэж 5,760.2 сая төгрөгийн хэмнэлттэй байна.

2014 оны санхүүгийн байдлын нэгтгэсэн тайлангаар 37,847.2 сая төгрөгийн нийт хөрөнгө илэрхийлэгдсэнээс 94.7 хувь буюу 35,849.2 сая төгрөгийн үндсэн хөрөнгө, 0.6 хувь буюу 227.1 сая төгрөгийн авлага болон урьдчилгаа, 4.2 хувь буюу 1,580.8 сая төгрөгийн бараа материал, 0.5 хувь буюу 190.1 сая төгрөгийн мөнгөн хөрөнгөтэй байна.

Нийт үндсэн хөрөнгийн 61.6 хувийг барилга байгууламж, 8.8 хувийг тээврийн хэрэгсэл, 13.1 хувийг машин тоног төхөөрөмж, 1.1 хувийг бусад үндсэн хөрөнгө, 9.8 хувийг дуусаагүй барилга байгууламж, 5.4 хувийг тавилга эд хогшил, 0.2 хувийг биет бус хөрөнгө эзэлж байна.

Үндсэн хөрөнгийн талаар: 2014 оны эхний үлдэгдэл 44,189.8 сая төгрөгийн үндсэн хөрөнгөтэй, тайлант хугацаанд 487.5 сая төгрөгийн үндсэн хөрөнгө худалдан авч, 460.5 сая төгрөгийн үндсэн хөрөнгө хандиваар хүлээн авсан, ТӨХ-ны тогтоолоор балансаас балансад 17,397.0 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг шилжүүлэн авч, бусад 3,789.8 сая төгрөгийн, нийт 22,134.8 сая төгрөгөөр үндсэн хөрөнгө нэмэгдэж, 750.7 сая төгрөгийн үндсэн хөрөнгө шилжүүлж, 742.5 сая төгрөгөөр үндсэн хөрөнгийг актлан хасагдсан, 76.7 сая төгрөгийн бусад ба хуримтлагдсан элэгдэл 21,189.5 сая төгрөгт хүрч, оны эцэст 43,565.1 сая төгрөгийн үлдэх өртөг бүхий хөрөнгөтэй байна.

Шилэн дансны мэдээлэл

Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын сайдын 2015 оны 4 дүгээр сарын 7-ны өдрийн А/50 дугаар тушаалаар шилэн дансны мэдээлэл, хэрэгжилтэд хяналт тавих журам, мэдээллийг иргэн, олон нийтэд хүргэх агуулгын жагсаалтыг баталсан байна.

Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын Төсвийн ерөнхийлөн захирагчийн нийт 98 байгууллагаас 95 байгууллага нь Шилэн дансны хуулийн хэрэгжилтийн талаарх судалгааг гаргаж өгсөн. Ахмадын асрамж, хөгжлийн үндэсний төв, Хараагүй хүмүүсийн хөдөлмөр, сургалтын үйлдвэр, Хүнс тэжээл, нийгмийн халамжийн төсөл-нэмэлт санхүүжилт 3086-МОН төсөл зэрэг 3 байгууллага одоогоор цахим хуудасгүй байна. Ахмадын асрамж, хөгжлийн үндэсний төв нь цахим хуудасгүй боловч www.shilendans.gov.mn цахим хуудсанд мэдээллээ шууд оруулсан байна.

Цаашид төсөв авч байгаа бүх байгууллагад энэ хуулийн хэрэгжилттэй холбоотойгоор цахим хуудастай байх, цахим хуудсандаа шилэн данс гэсэн цэстэй байх шалгуурыг тавьж байхыг сануулсан байна.

95 байгууллага байгууллагын болон Шилэн дансны цахим хуудсанд тавих 18 цэснээс 5 орчмыг нь тавих боломжтой бөгөөд түүнд дунджаар 1-36 мэдээ, мэдээлэл байршуулжээ. Иргэдийн шилэн дансны мэдээллийг үзсэн тоог харвал хамгийн бага нь БНСУ дахь Нийгмийн

хамгааллын төвийн шилэн дансны цэсний хандалт 14, хамгийн их нь Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын яамны цахим хуудсанд 6570 хандалт хийснээс “Худалдан авах ажиллагааны төлөвлөгөө”-г 2000 орчим буюу хамгийн их үзэж сонирхсон байна.

Мэдээ, мэдээллийн үнэн зөв, бодитой, иж бүрэн, ойлгомжтой, тогтмол шуурхай, тогтмол цаг хугацаанд, нээлттэй байх зэрэг шилэн дансны зарчмыг баримтлан ажиллаж байна.

Олж тогтоосон гол эрсдэлүүд, түүний үр дагавар

Аудитын төлөвлөгөөний дагуу аудитын 17 эрсдэлийг тогтоож, батламж мэдэгдлүүдийн хүрээнд данс бүрээр нийт 17 нарийвчилсан горим, сорил гүйцэтгэв.

Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын сайдын төсвийн багцын даргын багцад хамрагдах 62 төсвийн шууд захирагчдаас аудитад Хөвсгөл аймгийн Нийгмийн халамж үйлчилгээний хэлтэсээс бусад нь хамрагдаж, төсөвт зардлын 53.2 хувийг Үндэсний аудитын газар, 44.2 хувийг аймаг, нийслэлийн аудитын газар, 2.6 хувийг гэрээт хувийн аудитын компаниуд тус тус хамаарч санхүүгийн тайланд аудит хийсэн байна.

Аудитад хамрагдсан 62 салбар нэгжээс Хөвсгөл аймгийн, Чингэлтэй, Сонгинохайрхан дүүргийн болон Нийслэлийн Нийгмийн халамж үйлчилгээний хэлтэс, газрын санхүүгийн тайланд хязгаарлалтай дүгнэлт өгөгдсөн байна.

Гол, онцлог гүйлгээний талаарх (тохиромжтой бол) тайлбар

Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын сайдын төсвийн багцын 2014 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэдгийг, түүнийг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, аудитын явцад санхүүгийн тайланд нөлөөлөхүйц хэмжээний дүн бүхий Нийгмийн халамж үйлчилгээний ерөнхий газар, Хүүхдийн төлөө үндэсний газар, Сэргээн засах, хөгжлийн үндэсний төв, Олон Улсын хүүхдийн Найрамдал төв зэрэг газруудын аудит хийгдсэн санхүүгийн байдлын тайлан, санхүүгийн үр дүнгийн тайлан, мөнгөн гүйлгээний тайлан, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг нэгтгэл тайлан руу тулган баталгаажуулалт хийж шалгалаа. /ТАБ-СТА-В-3/

Аудитаар илрүүлсэн гол зөрчлүүд, тэдгээрийг шийдвэрлэсэн талаар

Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар хөндөгдсөн гол асуудлуудыг дараах заалтад хураангуйлан тэмдэглэв. Материаллаг байдлыг нийт зардлын 1 хувиар буюу 3,775.8 сая төгрөгөөр тооцсон.

Материаллаг бус дараах зөрчил илэрсэн байна. Үүнд:

Нийгмийн халамж үйлчилгээний ерөнхий газар нь 21 аймгийн НХҮХ, 9 дүүргийн НХҮХ, нийслэлийн НХҮГ, НХҮЕГ, Солонгос Улс дах нэг цэгийн үйлчилгээний төв, нийт 33 төсвийн шууд захирагчийн санхүүгийн тайланг нэгтгэж, төсвийн төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайланд ҮАГ аудитын дүгнэлт гаргасан боловч дээрх 33 байгууллагын санхүүгийн тайланг Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын сайдын төсвийн багцад нэгтгүүлж байгаа нь Төсвийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.36.-д “төсвийн ерөнхийлөн захирагч” гэж өөрийн эрхлэх асуудлын хүрээний төсвийг төлөвлөх, батлагдсан төсвийг хууль тогтоомжийн дагуу хуваарилах, хяналт тавих, захиран зарцуулах, гүйцэтгэлийг тайлагнах эрх бүхий этгээдийг;

4.1.37-д “төсвийн төвлөрүүлэн захирагч” гэж төсвийн ерөнхийлөн захирагчаас хуваарилсан чиг үүргийн төсвийг төлөвлөх, төсвийн шууд захирагчид хуваарилах, хяналт тавих, хууль тогтоомжийн дагуу захиран зарцуулах, гүйцэтгэлийг тайлагнах эрх бүхий этгээдийг; 22.6.5-д төсвийн ерөнхийлөн захирагч нь өөрийн батлагдсан төсвийг төсвийн төвлөрүүлэн захирагч бүрээр, төсвийн төвлөрүүлэн захирагчид харьяалагдахгүй төсвийг төсвийн шууд захирагч бүрээр, энэ хуулийн 22.2.3-22.2.6-д заасан ангиллаар, хүрэх үр дүнгийн хамт батлах; 22.6.6.төсвийн төвлөрүүлэн захирагч нь өөрийн батлагдсан төсвийг төсвийн шууд захирагч бүрээр, энэ хуулийн 22.2.3-22.2.6-д заасан ангиллаар, хүрэх үр дүнгийн хамт батлах; гэсэнтэй тус тус нийцэхгүй байна

Шийдвэрлэсэн нь Төсвийн тухай хуулийн хүрээнд асуудлыг шийдвэрлэж ажлын давхардлыг арилгаж, тайлангийн чанарт анхаарах талаар зөвлөмж өгөх

Яамны төвлөрсөн арга хэмжээнд 432.4 сая төгрөг зарцуулсан ба тухайлбал Монголын ахмадын чөлөөт холбоонд гэрээт санхүүжилт 150.2 сая, гадаад арга хэмжээ, гадаад томилолт 140.1 сая, яамны өдөрлөг, сурталчилгаа 56.2 сая, спортын арга хэмжээ 11.4 сая, хүн худалдаалах, хүчирхийллээс хамгаалах хөтөлбөр 10.0 сая, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн арга хэмжээ 9.5 сая, өсвөр үе, залуучуудын хөгжлийг дэмжих хөтөлбөр 8.7 сая, ахмадуудад хүндэтгэл үзүүлэх 8.3 сая, дотоод албан томилолт 5.3 сая, өрхийн хөгжлийг дэмжих хөтөлбөр 1.0 сая, сургалтын зардал 3.9 сая, автомашины засвар 6.5 сая, эрэгтэйчүүдийн чуулган 4.0 сая, судалгааны ажил 8.0 сая, яамны жуух, үнэмлэхний үнэ 6.4 сая, гэрээт ажлын санхүүжилт 2.4 сая, бусад үйлчилгээний хөлс 0.5 сая төгрөг тус тус зарцуулсан байгаа нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д: “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”; гэсэнтэй нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь Төсвийн тухай хуулийг баримтлаж ажиллах, батлагдсан төсвөөс гадуур зарцуулалтыг зогсоох, удирдлагын хяналтыг сайжруулах талаар зөвлөмж өгөх

Яамны аппаратын хэмжээнд ашиглагдаж байгаа 5 машин 2014 онд 10.7 сая төгрөгийн сэлбэг хэрэгсэл, 4.0 сая төгрөгийн даатгалын зардал, 3.3 сая төгрөгийн тос масло, 1.8 сая төгрөгийн машин угаалга, 1.7 сая төгрөгийн жижиг хэрэглэл, 0.6 сая төгрөгийн суудлын бүрээс, нийт 22.1 сая төгрөг зарцуулсан байна. Мөн 80.9 мянган километр туулж 32.4 сая төгрөгийн шатахуун хэрэглэсэн байна. Шатахууны тооцоог хийхдээ тооцоо бодсон актаар баталгаажуулаагүй, шатахуун зарцуулалтын норм баримтладаггүй, автомашин ашиглалтын дэвтэр хөтлөөгүй зэрэг дутагдлууд байгаа нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д: “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”; Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.7-д: “Анхан шатны баримтгүй ажил гүйлгээг бүртгэл, тайланд тусгахыг хориглоно” гэсэнтэй тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь Шатахууны тооцоог хийхдээ тооцоо бодсон актаар баталгаажуулах, шатахуун зарцуулалтын норм баримтлах талаар зөвлөмж өгөх

Санхүүгийн нэгтгэсэн тайлан, ерөнхий журнал, шалгах балансад тусгагдсан авлага, өглөг дансны ажил гүйлгээний дүнг авлага, өглөгийн тодруулга тайлангийн дүнтэй тулган шалгахад 18.9 сая төгрөгийн авлага, 52.5 сая төгрөгийн өглөгийг тус тус тооцоо нийлж актаар баталгаажуулаагүй нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1.4-д: “эд хөрөнгийн тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тогтоосон хугацаанд тооцоо нийлж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах” гэж заасантай нийцэхгүй байна.

2014 онд авлага 31,3 сая төгрөгөөр нэмэгдэж, авлагыг бууруулах талаар дорвитой ажил хийгдээгүй байгаа нь Төсвийн тухай хуулийн 6 дүгээр зүйлийн 6.4.8-д: “төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх” гэсэнтэй нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн дагуу авлага өглөгийг жил, улирлын эцэст тооцоо нийлж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулж байх, авлага, өр төлбөр үүсгэхгүй байхад анхаарч ажиллах талаар зөвлөмж өгөх

Салбар агентлагийн аудит хийгдсэн тайлангийн дүнг Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын сайдын төсвийн багцын нэгтгэсэн тайлантай тулгалт хийж 2014 оны тайланд 845.8 сая төгрөгийн алдаа зөрчил илэрснийг аудитын явцад залруулав.

Анхаарал татахуйц бусад чухал асуудал

Анхаарал татахуйц чухал асуудал үгүй байна.

Санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл

Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын сайдын төсвийн багцын 2014 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитаар нийт 1,560.3 сая төгрөгийн алдаа, зөрчил илэрсэн ба үүнээс 29.9 сая төгрөгийн 13 төлбөрийн акт, 47.7 сая төгрөгийн 8 албан шаардлага бичигдэж, 192.3 сая төгрөгийн 76 зөвлөмж өгч, 1,360.4 сая төгрөгийн 27 зөрчлийг аудитын явцад залруулав.

Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Төсвийн захирагчийн төсвийн 2013 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд Үндэсний аудитын газраас хийсэн аудитаар 2 зөвлөмж өгсөн бөгөөд зөвлөмж хэрэгжилт хангалтгүй байна.

Зөвлөмж

Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын сайдын төсвийн багцын 2014 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитаар 5 зөвлөмж өглөө.

Зөрчилгүй санал дүгнэлт

Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын сайдын төсвийн багцын 2014 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн болон илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүд холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн байна гэж үзэж. “зөрчилгүй” санал дүгнэлт өгөхийг Монгол Улсын Ерөнхий Аудиторт санал болгож байна.



**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ АУДИТОР**

210646 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
Бага тойруу, Засгийн газрын IV байр
Утас: 28-04-37, Факс: 32-32-66

2015.04.24 № 425

тавай _____-ны № _____-т

Аудитын гэрчилгээ

Г ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН
ЗАХИРАГЧ, ХҮН АМЫН ХӨГЖИЛ,
НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН САЙД
С.ЭРДЭНЭ ТАНАА

Төрийн аудитын тухай хуулийн 15 дүгээр зүйлийн 15.1.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.5-д заасны дагуу Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын сайдын төсвийн багцын 2014 оны 12 дүгээр сарын 31-ний өдрөөр дуусвар болсон жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлт, төсвийн гүйцэтгэлийн тайлан болон холбогдох бусад тайлбар тодруулга бүхий санхүүгийн нэгтгэсэн тайланд аудит хийв.

Үүрэг хариуцлагын талаарх мэдээлэл

Төсвийн ерөнхийлөн захирагч нь Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.3-т заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн нэгтгэсэн тайланг Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Санхүүгийн тайлангууд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт (УСНББОУС), түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмын дагуу үнэн зөв, бодитой илэрхийлэгдсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Санал дүгнэлтийн үндэслэл

Бид аудитыг Аудитын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журмын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр стандарт, журмын шаардлага нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэх явдал болно.

Аудитаар санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем, тэдгээрийг дэмжих нотлох зүйлийг сорилын үндсэн дээр шалгаж, удирдлагын хийсэн томоохон тооцооллыг үнэлж цэгнэн, санхүүгийн тайлангийн ерөнхий толилуулгыг үнэлсэн.

Бидний хийсэн аудит санал дүгнэлт өгөх хангалттай үндэслэл болно гэдэгт итгэлтэй байна.

Санхүүгийн аудитын мэдээлэл

Зөрчилгүй санал дүгнэлт

Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын сайдын төсвийн багцын 2014 оны 12 дүгээр сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн нэгтгэсэн тайланг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж Сангийн сайдын баталсан бодлого, аргачлал, журмын дагуу материаллаг зүйлсийн хувьд үнэн, шударга илэрхийлсэн байна.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ АУДИТОР



Санхүүгийн аудитын газар-А4 Бүлэг



ХҮН АМЫН ХӨГЖИЛ, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН САЙДЫН ТӨСВИЙН БАГЦЫН 2014 ОНЫ САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН

Менежментийн захидал

Тэргүүлэх ач холбогдол №1 зүйлс

Асуудал 1

Санхүүгийн тайлагналын талаар

Асуудал 2

Санхүүгийн тайлагналын талаар

Асуудал 3

Төвлөрсөн арга хэмжээний талаар

Асуудал 4

Шатахууны зарцуулалтын талаар

Авлага, өр төлбөрийн талаар

Менежментийн захидал

Үндэсний аудитын газар аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын сайдын төсвийн багцын удирдлагад зориулж бэлтгэсэн бөгөөд түүнд хяналтын сул тал буюу горимыг өөрчлөх замаар хяналтыг сайжруулах зөвлөмжийг өглөө.

Энэхүү менежментийн захидлын агуулга Аудитын олон улсын стандартын дагуу хийгддэг Үндэсний аудитын газрын аудитын горимоос урган гарсан болно. Санхүүгийн тайлангийн талаар санал дүгнэлт гаргахад бидний горим зориулагдсан. Энэ нь Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын сайдын төсвийн багцын хэрэгжүүлдэг нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянах бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын зөвлөмж нь дахин хяналт хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Үндэсний аудитын газар энэхүү зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд харин зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын сайдын төсвийн багцын ерөнхий нягтлан бодогч Ж.Ням-Осор болон салбарын санхүүгийн бусад ажилтнуудад талархал илэрхийлье.

Асуудал 1. Санхүүгийн тайлагналын талаар	Тэргүүлэх ач холбогдол №2 зүйлс
---	--

ҮАГ-ын ажиглалт

Төсвийн захирагчдын аудит хийгдсэн тайланг Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын сайдын төсвийн багцын нэгтгэл тайлантай тулган баталгаажуулах явцад 845.8 сая төгрөгийн алдаа зөрчлүүд илэрлээ.

Санхүүгийн тайланг нэгтгүүлэхэд илэрсэн дээрх зөрчил нь УСНББОУС 1, 15 дугаар стандарттай, Батламж мэдэгдлийн “Иж бүрэн байх: бүртгэгдээгүй хөрөнгө, өр төлбөр, ажил гүйлгээ, үйл явдал буюу дэлгэж харуулаагүй зүйл үгүй байх” УСНББОУС 1, 12 стандарттай, Батламж мэдэгдлийн Толилуулга ба илчлэл: “аливаа зүйлийг холбогдох санхүүгийн тайлагналын баримтлалын дагуу дэлгэн харуулж, ангилж, тодорхойлсон байх” гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

ҮАГ-ын зөвлөмж

Аудит хийгдсэн санхүүгийн тайланг Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын сайдын төсвийн багцын нэгтгэл тайланд нэгтгэхдээ сайтар хянаж, зөв нэгтгэх, харьяа байгуулагуудын санхүүгийн ажилтнуудын чадавхижуулах;

Эрсдэл

Санхүүгийн тайлан буруу илэрхийлэгдсэн байх;
Холбогдох хууль тогтоомж, журам, заавар, стандартыг баримтлаагүй байх;

Үйлчлүүлэгчийн хариу

Асуудлын бүртгэлийг үйлчлүүлэгчийн удирдлага, санхүүгийн ажилтанд танилцуулж баталгаажуулсан болно. Байгууллага хоорондын эдийн засгийн ангиллаар залруулга хийсэн.

Асуудал 2. Санхүүгийн тайлагналын талаар	Тэргүүлэх ач холбогдол №2 зүйлс
---	--

ҮАГ-ын ажиглалт

Нийгмийн халамж үйлчилгээний ерөнхий газар нь 21 аймгийн НХҮХ, 9 дүүргийн НХҮХ, нийслэлийн НХҮГ, НХҮЕГ, Солонгос Улс дах нэг цэгийн үйлчилгээний төв, нийт 33 төсвийн шууд захирагчийн санхүүгийн тайланг нэгтгэж, төсвийн төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайланд ҮАГ аудитын дүгнэлт гаргасан боловч дээрх 33 байгууллагын санхүүгийн тайланг Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын сайдын төсвийн багцад нэгтгүүлж байгаа нь Төсвийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.36.-д “төсвийн ерөнхийлөн захирагч” гэж өөрийн эрхлэх асуудлын хүрээний төсвийг төлөвлөх, батлагдсан төсвийг хууль тогтоомжийн дагуу хуваарилах, хяналт тавих, захиран зарцуулах, гүйцэтгэлийг тайлагнах эрх бүхий этгээдийг; 4.1.37-д “төсвийн төвлөрүүлэн захирагч” гэж төсвийн ерөнхийлөн захирагчаас хуваарилсан чиг үүргийн төсвийг төлөвлөх, төсвийн шууд захирагчид хуваарилах, хяналт тавих, хууль тогтоомжийн дагуу захиран зарцуулах, гүйцэтгэлийг тайлагнах эрх бүхий этгээдийг; 22.6.5-д төсвийн ерөнхийлөн захирагч нь өөрийн батлагдсан төсвийг төсвийн төвлөрүүлэн захирагч бүрээр, төсвийн төвлөрүүлэн захирагчид харьяалагдахгүй төсвийг төсвийн шууд захирагч бүрээр, энэ хуулийн 22.2.3-22.2.6-д заасан ангиллаар, хүрэх үр дүнгийн хамт батлах; 22.6.6.төсвийн төвлөрүүлэн захирагч нь өөрийн батлагдсан төсвийг төсвийн шууд захирагч бүрээр, энэ хуулийн 22.2.3-22.2.6-д заасан ангиллаар, хүрэх үр дүнгийн хамт батлах; гэсэнтэй тус тус нийцэхгүй байна.

Эрсдэл

Санхүүгийн тайлан буруу илэрхийлэгдсэн байх;

ҮАГ-ын зөвлөмж

Төсвийн тухай хуулийн хүрээнд асуудлыг шийдвэрлэж ажлын давхардлыг арилгаж, тайлангийн чанарт анхаарч ажиллах;

Үйлчлүүлэгчийн хариу

Асуудлын бүртгэлийг үйлчлүүлэгчийн удирдлага, санхүүгийн ажилтанд танилцуулж баталгаажуулсан болно.

Асуудал 3. Төвлөрсөн арга хэмжээний талаар

Тэргүүлэх ач холбогдол №2 зүйлс

ҮАГ-ын ажиглалт

Яамны төвлөрсөн арга хэмжээнд 432.4 сая төгрөг зарцуулсан ба тухайлбал Монголын ахмадын чөлөөт холбоонд гэрээт санхүүжилт 150.2 сая, гадаад арга хэмжээ, гадаад томилолт 140.1 сая, яамны өдөрлөг, сурталчилгаа 56.2 сая, спортын арга хэмжээ 11.4 сая, хүн худалдаалах, хүчирхийллээс хамгаалах хөтөлбөр 10.0 сая, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн арга хэмжээ 9.5 сая, өсвөр үе, залуучуудын хөгжлийг дэмжих хөтөлбөр 8.7 сая, ахмадуудад хүндэтгэл үзүүлэх 8.3 сая, дотоод албан томилолт 5.3 сая, өрхийн хөгжлийг дэмжих хөтөлбөр 1.0 сая, сургалтын зардал 3.9 сая, автомашины засвар 6.5 сая, эрэгтэйчүүдийн чуулган 4.0 сая, судалгааны ажил 8.0 сая, яамны жуух, үнэмлэхний үнэ 6.4 сая, гэрээт ажлын санхүүжилт 2.4 сая, бусад үйлчилгээний хөлс 0.5 сая төгрөг тус тус зарцуулсан байна.

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д: “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”; Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.7-д: “Анхан шатны баримтгүй ажил гүйлгээг бүртгэл, тайланд тусгахыг хориглоно” гэсэнтэй тус тус нийцэхгүй байна.

Эрсдэл

Холбогдох хууль, тогтоол, журам, заавар зөрчсөн байх;

ҮАГ-ын зөвлөмж

Төсвийн тухай хуулийг баримтлаж ажиллах, батлагдсан төсвөөс гадуур зарцуулалтыг зогсоох, удирдлагын хяналтыг сайжруулах;

Үйлчлүүлэгчийн хариу

Асуудлын бүртгэлийг үйлчлүүлэгчийн удирдлага, санхүүгийн ажилтанд танилцуулж баталгаажуулсан болно.

Асуудал 4. Шатахууны зарцуулалтын талаар

Тэргүүлэх ач холбогдол №2 зүйлс

ҮАГ-ын ажиглалт

Яамны аппаратын хэмжээнд ашиглагдаж байгаа 5 машин 2014 онд 10.7 сая

ҮАГ-2015/11/СТА-ТЕЗ

ҮАГ-ын зөвлөмж

Шатахууны тооцоог хийхдээ тооцоо бодсон актаар баталгаажуулах, шатахуун

төгрөгийн сэлбэг хэрэгсэл, 4.0 сая төгрөгийн даатгалын зардал, 3.3 сая төгрөгийн тос масло, 1.8 сая төгрөгийн машин угаалга, 1.7 сая төгрөгийн жижиг хэрэглэл, 0.6 сая төгрөгийн суудлын бүрээс, нийт 22.1 сая төгрөг зарцуулсан байна. Мөн 80.9 мянган километр туулж 32.4 сая төгрөгийн шатахуун хэрэглэсэн байна.

Шатахууны тооцоог хийхдээ тооцоо бодсон актаар баталгаажуулаагүй, шатахуун зарцуулалтын норм баримтладаггүй, автомашин ашиглалтын дэвтэр хөтлөөгүй зэрэг дутагдлууд байна. Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д: “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”; Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.7-д: “Анхан шатны баримтгүй ажил гүйлгээг бүртгэл, тайланд тусгахыг хориглоно” гэсэнтэй тус тус нийцэхгүй байна.

зарцуулалтын норм баримтлах;

Эрсдэл

Холбогдох хууль, тогтоол, журам, заавар зөрчсөн байх;

Үйлчлүүлэгчийн хариу

Асуудлын бүртгэлийг үйлчлүүлэгчийн удирдлага, санхүүгийн ажилтанд танилцуулж баталгаажуулсан болно.

Асуудал 5. Авлага өглөгийн талаар

Тэргүүлэх ач холбогдол №2 зүйлс

ҮАГ-ын ажиглалт

Санхүүгийн нэгтгэсэн тайлан, ерөнхий
ҮАГ-2015/11/СТА-ТЕЗ

ҮАГ-ын зөвлөмж

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн

журнал, шалгах балансад тусгагдсан авлага, өглөг дансны ажил гүйлгээний дүнг авлага, өглөгийн тодруулга тайлангийн дүнтэй тулган шалгахад 18.9 сая төгрөгийн авлага, 52.5 сая төгрөгийн өглөгийг тус тус тооцоо нийлж актаар баталгаажуулаагүй нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1.4-д: “эд хөрөнгийн тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тогтоосон хугацаанд тооцоо нийлж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах” гэж заасантай нийцэхгүй байна.

2014 онд авлага 31,3 сая төгрөгөөр нэмэгдэж, авлагыг бууруулах талаар дорвитой ажил хийгдээгүй байгаа нь Төсвийн тухай хуулийн 6 дүгээр зүйлийн 6.4.8-д: “төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх” гэсэнтэй нийцэхгүй байна.

дагуу авлага өглөгийг жил, улирлын эцэст тооцоо нийлж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулж байх, авлага, өр төлбөр үүсгэхгүй байхад анхаарч ажиллах;

Эрсдэл

Авлага, өглөгийг тооцоо нийлж, актаар баталгаажуулаагүй, санхүүгийн тайланд авлага, өр төлбөр зөрүүтэй илэрхийлэгдсэн байх;

Үйлчлүүлэгчийн хариу

Асуудлын бүртгэлийг үйлчлүүлэгчийн удирдлага, санхүүгийн ажилтанд танилцуулж баталгаажуулсан болно.

СТ-1А

АУДИТ ХИЙГДСЭН САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

2014 оны 12 сарын 31-ний байдлаар

/төгрөгөөр/

БАЛАНСЫН ЗҮЙЛ	ЭХНИЙ ҮЛДЭГДЭЛ	ЭЦСИЙН ҮЛДЭГДЭЛ
МӨНГӨН ХӨРӨНГӨ	302,057,535.66	190,077,667.44
Кассанд байгаа бэлэн мөнгө	1,369,870.40	13,600.00

Төгрөг\ ЖМС	1,369,870.40	13,600.00
Банкинд байгаа бэлэн мөнгө	300,687,665.26	190,064,067.44
Төгрөг	300,687,665.26	190,064,067.44
Төсөвт байгууллагын харилцах /Төрийн сан/	-	3,812,700.00
Төсөвт байгууллагын харилцах	0.01	-
Төсөвт байгууллагын харилцах /Арилжааны банк/	210,696,582.21	186,251,367.44
Нэмэлт санхүүжилтын харилцах	89,991,083.04	-
АВЛАГА	182,880,905.63	214,153,628.66
Ажиллагчидтай холбогдсон авлага	1,188,031.71	1,747,449.70
Төлбөртэй үйлчилгээний авлага	18,365,797.50	9,202,357.00
Татаас, санхүүжилтийн авлага		7,387,900.00
Бусад авлага	163,327,076.42	195,815,921.96
Байгууллагаас авах авлага	93,462,270.02	132,316,558.86
	600,000.00	
Бусад зардлын тооцооны авлага	92,862,270.02	132,316,558.86
Хувь хүмүүсээс авах авлага	69,864,806.40	63,499,363.10
Урьдчилгаа	123,519,297.00	12,983,119.00
Бусад урьдчилгаа	123,519,297.00	12,983,119.00
Урьдчилж гарсан зардал	123,519,297.00	12,983,119.00
Урьдчилж төлсөн зардал	123,519,297.00	12,983,119.00
БАРАА МАТЕРИАЛ	1,350,897,843.07	1,580,783,310.79
Түүхий эд материал	52,664,831.65	100,782,747.60
Тусгай зориулалттай материал	36,152,550.20	71,973,997.98
Эм боох материал	3,598,721.75	6,785,157.42
Бэлэн бүтээгдэхүүн	12,913,559.70	22,023,592.20
Хангамжийн материал	1,268,685,611.42	1,444,053,663.19
Бичиг хэргийн материал	38,843,442.06	57,630,388.99
Аж ахуйн материал	605,863,634.05	563,555,948.30
Сэлбэг хэрэгсэл	14,196,526.00	25,214,980.00
Түлш, шатах тослох материал	38,376,366.61	41,691,493.57
Барилгын засварын материал	412,300.00	3,538,133.00
Хүнсний материал	113,490,265.79	158,629,012.73
Баглаа боодол	223,750.00	151,250.00
Бусад бараа материал	457,279,326.91	593,642,456.60
Мал амьтад	29,547,400.00	35,946,900.00
ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	1,959,355,581.36	1,997,997,725.89
ҮНДСЭН ХӨРӨНГӨ	24,504,734,340.12	43,565,080,454.78
Биет хөрөнгө	24,489,005,479.82	43,501,570,967.00
Барилга, байгууламж, орон сууц	18,564,213,709.71	22,093,707,034.70
Барилга, байгууламж орон сууц - Анхны өртөг	32,554,251,187.99	36,843,525,943.99
Барилга, байгууламж орон сууц - Хуримтлагдсан элэгдэл	(13,990,037,478.28)	(14,749,818,909.29)
Авто-тээврийн хэрэгсэл	1,247,987,092.59	3,156,205,189.55

Авто-тээврийн хэрэгсэл анхны өртөг - Анхны өртөг	2,273,863,839.09	4,221,140,030.46
Авто-тээврийн хэрэгсэл - Хуримтлагдсан элэгдэл	(1,025,876,746.50)	(1,064,934,840.91)
Машин тоног төхөөрөмж(компьютер)	2,865,064,659.11	4,711,997,575.77
Машин тоног төхөөрөмж(компьютер) - Анхны өртөг	5,956,616,389.82	8,223,981,757.29
Машин тоног төхөөрөмж(компьютер) - Хуримтлагд/ элэгдэл	(3,091,551,730.71)	(3,511,984,181.52)
Тавилга, аж ахуйн эд хогшил	1,346,691,975.25	1,932,059,405.75
Тавилга, аж ахуйн эд хогшил - Анхны өртөг	2,590,681,725.09	3,300,014,349.21
Тавилга, аж ахуйн эд хогшил - Хуримтлагдсан элэгдэл	(1,243,989,749.84)	(1,367,954,943.46)
Зам, гүүрийн байгууламж	-	-
Зам, гүүрийн байгууламж - Анхны өртөг	5,850,000.00	5,850,000.00
Зам, гүүрийн байгууламж - Хуримтлагдсан элэгдэл	(5,850,000.00)	(5,850,000.00)
Бусад үндсэн хөрөнгө	444,830,936.32	395,095,510.23
Бусад үндсэн хөрөнгө - Анхны өртөг	748,931,447.53	855,742,455.53
Бусад үндсэн хөрөнгө - Хуримтлагдсан элэгдэл	(305,574,161.21)	(462,885,777.67)
Номын фонд	1,473,650.00	2,238,832.37
Дуусаагүй барилга, байгууламж	20,217,106.84	11,212,506,251.00
Биет бус хөрөнгө	15,728,860.30	63,509,487.78
Програм хангамж	10,728,860.30	59,009,487.82
Програм хангамж - Анхны өртөг	32,876,934.00	84,606,934.00
Програм хангамж - Хуримтлагдсан элэгдэл	(22,148,073.70)	(25,597,446.18)
Бусад биет бус хөрөнгө	5,000,000.00	4,499,999.96
Бусад биет бус хөрөнгө - Анхны өртөг	5,000,000.00	5,000,000.00
Бусад биет бус хөрөнгө - Хуримтлагдсан элэгдэл		(500,000.04)
НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	26,464,089,921.48	45,563,078,180.67
